



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 270 дугаар тушаалын Төртогтох овогтой Сармандахтай холбогдолтой хэсгийн “Австрали улсын Бонд их сургуулийн” гэснийг “Австрали улсын Брисбени хотын Griffith их сургуулийн” гэж өөрчилж, мөн суралцах хугацааг 0.5 жилээр сунгасугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 412 дугаар тушаалын Лхагва овогтой Лхагвасүрэнтэй холбогдолтой хэсгийн “Австрали улсын Queensland их сургуулийн” гэснийг “Sydney Business & Travel Academy” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 417 дугаар тушаалын Көбейхан овогтой Булбултай холбогдолтой хэсгийн “АНУ-ын Бриджпортын их сургуулийн” гэснийг “Англи улсын London School of Commerce сургуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 270 дугаар тушаалын Т.Сармандахтай, 2007 оны 412 дугаар тушаалын Л.Лхагвасүрэнтэй, 2007 оны 417 дугаар тушаалын К.Булбултай холбогдолтой хэсгүүдийг хүчингүй болсонд тус тус тооцсугай.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

Ё.ОТГОНБАЯР